



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 01 сарын 28 өдөр

Дугаар A/05


Улаанбаатар хот

┌ Спорт наадам зохион байгуулах ┐
ажлын хэсэг байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.2 дах хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Хөдөлмөрийн дотоод журмын 6.2.10 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл агаар-РИО 2016" сэдэвт цасны баяр, биеийн тамир, спортын өвлийн арга хэмжээг зохион байгуулсугай.
2. Спортын наадмын арга хэмжээний зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээний зардлыг хоёрдугаар хавсралтаар, удирдамжыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дээрх наадмын үйл ажиллагаанд зарцуулагдах 1,688.400 /Нэг сая зургаан зуун наян найман мянга дөрвөн зуун/ төгрөгийг нийгмийн арга хэмжээний зардлаас тооцон гаргахыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Ё.Мөнхтуул/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа дэмжих асуудал хариуцсан Орлогч дарга /С.Майнбаяр/-г даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН